



СЭЛЭНГЭ АЙМАГ
САНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

᠒᠐23 оны ᠐5 сарын ᠒5 өдөр

Дугаар А/᠖5

Сант сум

Бэлчээр чөлөөлөх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, 59.1.23, Газрын тухай хуулийн 52.2, сумын иргэдийн Төлөөлөгчдын Хурлын 2020 оны 08 дугаар сарын 19-ны өдрийн 70 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын бэлчээр ашиглах журмыг хэрэгжүүлэх, өвөлжөө, хаваржааны бэлчээр, хот тосгоны суурин газрын бэлчээрийг малын хөлөөс чөлөөлөх хугацааг 2023 оны 5 дугаар сарын 15-ны өдрөөр тогтоосугай.

2.Тогтоосон хугацааг мөрдүүлэх, энэхүү захиргааны актыг малчин, мал бүхий иргэдэд хүргэх ажлыг 2023 оны 5 дугаар сарын 15-ны өдрөөс өмнө зохион байгуулж ажиллахыг багийн Засаг дарга (Л.Сэлэнгэсайхан, Б.Золбаяр) нарт үүрэг болгосугай.

3.Энэхүү захиргааны актаар тогтоосон хугацаанаас хойш бэлчээр чөлөөлөөгүй малчин, мал бүхий иргэдэд албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэх, хариуцлага тооцох хяналт шалгалтын арга хэмжээг хэрэгжүүлж ажиллахыг Байгаль орчны хяналтын улсын байцаагч (А.Батдорж)-д үүрэг болгосугай.

4.Энэ захиргааны актын биелэлтэнд хяналт тавих, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (А.Одхүү)-д үүрэг болгосугай.

5.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн А/56 тоот захирамжийг хүчингүйд тооцсугай.



С.ШИЖИРБААТАР

Боловсруулсан: Д. Оюун-Эрдэнэ
Хянасан: Ч. Аюулбаяр
Хувь: 2